



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/102


Бор-Өндөр сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй
болгох тухай**


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээнд заасан зориулалтын дагуу газраа 2 ба түүнээс дээш жил хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ашиглаагүй иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосугай.
2. Газар эзэмших эрхийн гэрчилгээ нь хүчингүй болж байгаа иргэн, аж ахуйн нэгж болон газрын мэдээллийг нэгдүгээр хавсралтад дурдсугай.
3. Уг захирамж гарсантай холбогдуулан хавсралтад дурдагдсан иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмшүүлэх гэрээг цуцалж, мэдээллийн санд холбогдох өөрчлөлтийг тусгахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ГАДЪЯАБИЛЭГТ



Сумын Засаг даргын 2024 оны 6-р сарын 07-ны өдрийн
А/102-р захирамжийн нэгдүгээр хавсралт

Газар болон эзэмшигчийн мэдээлэл

	Эзэмшигчийн		Газрын				Газар олгогдсон захирамжийн	
	Иргэн /хуулийн этгээд/-ийн нэр	Регистр	Хэмжээ /мкв/	Хаяг	Зориулалт	Нэгж талбарын дугаар	Захирамжийн огноо	Дугаар
Д/Д	1	2	3	4	5	6	7	8
0					Уул уурхайн үйлдвэрлэл	2322003270	2021.12.08	A/270
1	Ш.Бямбасүрэн	СЦЦ71060118	7500	6-р баг, Өлгийн зам, 07 тоот				